



Монголын Хөрөнгийн Биржийн гишүүн
Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
“БиДиСЕК ҮЦК” ХК

АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот
2018 он

Андеррайтерийн дүгнэлт

Тус компани нь Канад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, тус улсын Хөрөнгийн биржид бүртгэлтэй (Торонтогийн Хөрөнгийн Бирж-TSX) Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн (“Үнэт цаас гаргагч”)-ийн үнэт цаасыг Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлэх үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар 2018 оны 01 сарын 31-ны өдөр андеррайтерийн гэрээ байгуулсан.

Үнэт цаас гаргагчийн компанийн өнөөгийн үйл ажиллагаа, эзэмшиж буй орд газруудын мэдээлэл, хөрөнгө оруулалтын боломж, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, эрх бүхий этгээдийн шийдвэр болон бусад холбогдох баримт, материалуудыг хянан үзэж Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгүүлэхээр үнэт цаасны бүрдүүлбэрийг бэлтгэн хүргүүлж байна.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн өгсөн цаасан болон цахим хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн шинжээч, аудит, хуулийн үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн тайлан, дүгнэлт, түүнд агуулагдсан мэдээ, мэдээллийг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан болно.

Нэг. Компанийн өнөөгийн үйл ажиллагаа, ирээдүйн боломжийн талаар

1.1 Үнэт цаас гаргагчийн түүх, өнөөгийн үйл ажиллагаа

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорейшн нь Монгол Улсад ашигт малтмалын ордын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагааг 2002 оноос эрхэлж эхэлсэн. Тус компани 2000 оны 07 сарын 14-нд Канадын Бизнесийн Корпорацийн Хуулийн дагуу “3779751 Канада Инк” нэрээр үүсгэн байгуулагдсан бол компанийн нэрийг 2003 онд “Эрдэнэ Гоулд Инк”, 2008 онд Эрдэнэ Ресурс Девелопмент Корп болгон тус тус өөрчилсөн байна.

Үнэт цаас гаргагч нь анх 2004 оны 03 сарын 16-нд Торонтогийн Хөрөнгийн биржийн Венчур самбарт (“TSX-V”) бүртгүүлэн нийт 12,500,000 ширхэг энгийн хувьцааг нэгж бүрийг \$0.85 доллараар олон нийтэд санал болгон арилжсан. Улмаар 2005 оны 12 сарын 14-өөс компанийн хувьцаа Торонтогийн Хөрөнгийн биржийн үндсэн ангилалд (“TSX”) шилжин арилжаалагдаж эхэлсэн байна.

Үнэт цаасаа олон нийтэд санал болгох үедээ худалдан авалтын гэрээний дагуу болон хувь эзэмших эрхтэйгээр Монгол улсад 19 ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг эзэмшиж байжээ. Тусгай зөвшөөрөлтэй талбайнуудад хайгуулын ирээдүй бүхий найман талбай байсан бөгөөд эдгээр нь Монгол улсын өмнөд-төв болон зүүн-өмнөд бүсийн нутгуудад төвлөрсөн байсан. Эдгээр тусгай зөвшөөрөл бүхий талбайг порфирын төрлийн алт болон зэсийн орд агуулах боломжтой гэж таамаглан анх сонгож авсан хэдий ч компанийн хийсэн хайгуулын ажлаар тус талбайнуудад дэлхийн хэмжээний нөөцтэй томоохон ордыг

нээн илрүүлэх боломжгүй гэж үзсэн тул дийлэнх хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг холбогдох байгууллагад буцаан өгсөн байна.

Үнэт цаас гаргагч нь одоогийн байдлаар 17,861.20 га бүхий 7 төслийн талбайд ашигт малтмалын хайгуулын 4, ашиглалтын 1 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба эдгээрийг өөрийн охин компаниудын нэр дээр эзэмшдэг (Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК болон Лидер эксплорейшн ХХК).

Компанийн хэрэгжүүлж байгаа төслүүд

- Баян хөндийн алтны төсөл,
- Алтан нар алт-полиметаллын төсөл,
- Алтан сум алт-мөнгөний төсөл,
- Зуун мод молибден-зэсийн төсөл,
- Хөвийн хар зэс-мөнгөний төсөл,
- Улаан зэс-порфирын хайгуул,
- Бусад анхан шатны хайгуулын төслүүд багтаж байна.

Компанийн одоогийн хайгуул, уул уурхайн тусгай зөвшөөрлийн тухай мэдээлэл

Хүснэгт 1. Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн тухай (Эрдэнэ Монгол ХХК)

#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Олгосон жил	Дуусах хугацаа	Дуусах хугацаа*
1	Цэнхэр Номин	XV-016956	Баянхонгор	Баян-Өндөр /Шинэжинст	4,668.64	11-12-0	9	18-1-11	21-12-11
2	Хөндий	XV-015569	Баянхонгор	Шинэжинст	4,514.33	10-3-14	8	19-3-14	22-4-14
3	Бургаст	XV-017875	Говь-Алтай	Цогт	857.00	15-6-8	3	18-5-8	27-6-8

Дуусах хугацаа - хайгуулын тусгай зөвшөөрөл эцэслэн дуусах хугацаа*

Хүснэгт 2. Компанийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тухай (Аниан Ресурс ХХК)

#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Одоог хүртэл олгосон жил	Одоогоор дуусах хугацаа
1	Хөвийн хар	MV-016836	Баянхонгор	Шинэжинст	6,041.03	11-5-26	7	41-4-26

Тайлбар - 7 дах жилийн төлбөрийг төлсөн

Хүснэгт 3. Компанийн хайгуулын тусгай зөвшөөрлийн тухай (Лидер хайгуул ХХК)

#	Эзэмшлийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Аймаг	Сум	Га	Олгосон огноо	Одоог хүртэл олгосон жил	Дуусах хугацаа	Дуусах хугацаа*
1	Улаан	XV-016057	Баянхонгор	Баян-Өндөр /Шинэжинст	1,780.20	15-2-16	3	21-1-16	27-2-16

Дуусах хугацаа - хайгуулын тусгай зөвшөөрөл дуусах хугацаа*

Үнэт цаас гаргагч нь Цэнхэр Номин тусгай зөвшөөрөлт талбайд Алтан Нар төслийн талбайг ялгаж Нээлтийн бүс, Хойд Холбоо гэж нэрлэсэн газруудад орд тогтоож, Номинт зэрэг цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай талбайнуудыг мөн олж илрүүлсэн. Мөн Хөндий нэртэй тусгай зөвшөөрөлт талбайн хэмжээнд Баян Хөндий төслийн талбайг ялгаж алтны өндөр агуулгатай Хүрэн цав илрэлийг нээж илрүүлсэн байна. Хүрэн цав илрэл нь хамгийн сайн хүдэржсэн бүс бөгөөд гадаргуугаас нүдэнд үзэгдэх алттай кварцын судлууд цөөнгүй ажиглагддаг, анхдагч геохимийн сорьцлолтоор нүдэнд үзэгдэх алттай дээжид нэн өндөр алтны агуулга тогтоогдсон ба дунджаар 5-10г/т байсан талаар хөндлөнгийн мэргэжлийн дүгнэлтэнд дурджээ.

Баян Хөндий төслийн талбайд цаашид үргэлжлүүлэн хайгуул судалгааны ажил явуулан Зүүн Хойд, Алтан Арроу зэрэг талбайнуудыг мөн тогтоогоод байгаа.

Уг ордуудын хувьд ил уурхайгаар олборлох боломжтой эдийн засгийн үр ашиг өндөртэй “Дэлхийн хэмжээний” хүдрийн биет гэж үзэж ач холбогдол өгч байгаа бол Зуун Мод болон Хөвийн Хар төслүүд нь компанийн ойрын ирээдүйн эн тэргүүний зорилтууд биш гэж үздэг байна.

1.2 Хөрөнгө оруулалтын боломж

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг 2018 оны 02 сарын 28 өдөр гаргасан.

Өнөөгийн байдлаар Компанийн Баян Хөндий болон Алтан Нар ордууд ил аргаар олборлож болохуйц, өндөр эрдэсийн агуулга бүхий хүдрийн нөөцтэй байх магадлал өндөр байгаа бөгөөд компанийн Хөндий болон Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийн талбайн 12 ширхэг эрдэсийн илрэл нь мөн алт болон полиметаллын орд байх магадлалтай юм. Хэрэв дээрх илрэлүүд дээр хангалттай хэмжээний эрдэсийн нөөц тогтоосон тохиолдолд компанийн зах зээлийн үнэлгээ өсөх, хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг өсгөх боломж бий болно.

Компанийн үйл ажиллагаа нь хайгуулаас ашиглалтын үйл ажиллагаа хүртэл ирээдүйд өсөн дэвших бололцоотой бөгөөд дараах боломжийг харж байна.

- Хайгуулаас ашиглалт уруу чиглэсэн

Компанийн үйл ажиллагаа одоогоор хайгуулын шатандаа явж буй хэдий ч цаашид ашиглалт, олборлолтын шатруу шилжих боломжтой шинэ алтны бүсийг нээн илрүүлсэн нь ирээдүйд хөрөнгө оруулагчдад үнэ цэнийг бий болгоно гэж үзэж байна. Одоогийн голлох төслүүд болох Баян Хөндий, Алтан Нар төслүүд нь эрдэс баялгийн нөөц тооцоолоход хэмжээ болон чанарын хувьд өсөн нэмэгдэх боломжтой.

Баян Хөндий хайгуулын бүс дэх өрөмдлөг, техникийн судалгааны үр дүнгээс харахад гадаргад ойр, өндөр агуулга бүхий хүдрийн биет байгаа ба уламжлалт химийн уусмалын аргаар олборлох боломжтой (металл авалтын хэмжээ 92%-99%). Мөн Алтан Нар төслийн хүрээнд боловсруулсан NI 43-101 эрдсийн нөөцийн хэмжээ дахин өсөх боломжтой хэмээн Компани үзэж байна. 2018 онд багтаан Компани Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн эрдсийн нөөцийг тооцоолох төлөвлөгөөтэй.

Компанийн удирдлага нь Монгол Улсын хайгуулын салбарт 20 гаруй жил ажилласан, Монгол Улсын хууль, эрх зүй, байгаль орчин болон бизнесийн нөхцөл байдлын талаар өргөн мэдлэгтэй баг хамт олон. Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн 2018 оны өрөмдлөгийн үр дүн болон эрдсийн нөөцийн тооцоолол нь хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын үнэ цэнэд эерэгээр нөлөөлөх боломжтой.

- Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан шинэ алтны ордын нээлтэд хөрөнгө оруулах боломж

МХБ-д бүртгэлтэй нийт 218 компанийн дунджаар 7% нь уул уурхайн компаниуд байна. Гэвч энэхүү уул уурхайн компаниудын дийлэнх нь төрийн эзэмшлийн нүүрс олборлолтын компаниуд байна.

Энэхүү бүртгэл нь МХБ-д бүртгэгдэж буй анхны давхар бүртгэл бөгөөд Компанид Монгол Улсын хөрөнгийн зах зээлд олон улсын стандартын дагуу, үйл ажиллагааг эрхлэх нөхцөлийг бий болгон, хөрөнгө оруулагчдад шинэ хөрөнгө оруулалтын боломжийг олгож байна. Хэдийгээр хайгуулын үйл ажиллагаа нь эрсдэл өндөр боловч Компанийн Баян Хөндий болон Алтан Нар төсөл нь газрын гадаргад ойр, өндөр агууламж бүхий орд болох боломжтой хүдрийн биет байгаа нь энэхүү эрсдэлийг бууруулах магадлалтай. Үнэт цаас гаргагч нь цаашид үргэлжлүүлэн ашигт малтмалын хайгуулын ажлуудыг хийх төлөвлөгөөтэй байгаа нь хөрөнгө оруулагчид, засаг захиргааны байгууллагууд болон орон нутгийн үйл ажиллагаанд үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

- Алтны эрэлт болон Монгол Улсад нөлөөлөх нөлөөлөл

Монгол Банкны алт худалдан авалт 2017 онд түүхэн дээд хэмжээнд хүрсэн. Тушаах алтны хэмжээг нэмэгдүүлэх, алт худалдан авах үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан тогтоох үүднээс Монголбанкнаас “Алт” нэртэй хөтөлбөрийг эхлүүлсэн.

2016 оноос 2020 он хүртэл Монгол улсын Засгийн Газар “Алт-2” хөтөлбөрийг 2 үе шатанд хуваан хэрэгжүүлж байгаа ба энэхүү хөтөлбөрийн хүрээнд алтны эрэл хайгуулыг нэмэгдүүлэх, Монгол улсын алтны нөөцийг 150 тонн хүртэл нэмэгдүүлэх, алтны олборлолтын хэмжээг жилд 2-3 тонноор өсгөх, салбарын хууль эрх зүйн таатай, тогтвортой орчин бүрдүүлэх төлөвлөгөөтэй.

Дотоодын эрэлтээс гадна төслийн талбай нь дэлхийн хамгийн том алтны олборлогч болон хоёрдогч том хэрэглэгч улстай ойр байрладаг. Хятад улс нь дэлхийн алтны хэрэглээний гуравны нэгийг эзэлдэг бөгөөд хамгийн том олборлогч улс юм. Олборлолтын өртөг өсч, алтны ордуудын дундаж агууламжийн хэмжээ буурч байгаа тул цаашид урт хугацаанд алтны эрэлт ба үнэлгээ өсөх хандлагатай байна.

Хоёр. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц, ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын талаар

2.1 Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Үнэт цаас гаргагч нь хязгааргүй тооны энгийн хувьцаа гаргах зөвшөөрөлтэй ба уг танилцуулгыг олон нийтэд танилцуулах үед **146,400,586** энгийн хувьцаатай байна.

Хувьцаа эзэмшигчид	Одоогийн байдлаар	
	Хувьцааны тоо хэмжээ	Хувь
Teck Resources Ltd	13,222,904	9.03%
ТУЗ-ийн гишүүд, захирлууд	13,644,752	9.32%
Нийтэд арилжаалагдаж буй	119,532,930	81.65%
Нийт	146,400,586	100%

2.2 Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”) нь найман гишүүнээс бүрдэх ба эдгээрийг 2017 оны 06 сарын 14-ний өдрийн ХЭЭБХ-р томилсон тул гишүүд өөрт олгогдсон эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрх хэмжээтэй байна¹. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх нь Канадын Үнэт Цаасны холбогдох хууль эрх зүйн шалгуурт нийцсэн “хараат бус” гишүүд байдаг.

Хараат бус гишүүд: Др Анна Г. Биолик (Dr. Anna G. Biolik), Виллиам Б. Бартон (William B. Burton), Жон П. Бюрн (John P. Byrne), Т.Лэйтон Крофт (Layton Croft), Дэвид В. Мошер (David V. Mosher) ба Филипп Л.Вэбстер (Philip L. Webster).

Ердийн гишүүд: Компанийн Гүйцэтгэх захирал Петер С.Акерли, Ж.К Кован.

2.3 Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дэргэдэх хороод, дотоод хяналт

Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Компанийн бизнесийн үйл ажиллагаа болон удирдлагын гүйцэтгэлд хяналт тавих үүргийг хариуцдаг. Энэхүү үүргийг ТУЗ нь шууд болон дараах таван хороогоор дамжуулан гүйцэтгэдэг байна.

- Аудитын хороо

¹ Хавсралт 10. Эрдэнэ Ресорс Девелопмент Корпорэйшний Монголын Хөрөнгийн Биржид гаргах энгийн хувьцааны давхар бүртгэлд зориулсан хууль зүйн дүгнэлт.

Аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явц болон дотоод хяналтын системийг бие даасан, бодит байр сууринаас хянаж, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд нь ТУЗ-д дэмжлэг үзүүлэн ажилладаг. Мөн Компанийн санхүүгийн хэлтэс, удирдлага болон хөндлөнгийн аудиторруудыг холбох, ил тод байдлыг хангах болон хөндлөнгийн аудиторын ажил үүрэгт дотоод хяналт тавих үүрэгтэй.

- Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хорооны эрх үүрэг нь Компанийн гүйцэтгэх албан тушаалтнууд, мэргэжилтнүүдийн ажлын гүйцэтгэл, цалин урамшууллыг хянан шалгах, төлөвлөгөөний дагуу зохистой удирдлагыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Цалин урамшууллын хороо нь Гүйцэтгэх захиралтай хамтран харьцуулсан судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр ТУЗ-ийн гишүүдэд өгөх цалин урамшууллын түвшинг ТУЗ-д санал болгодог.

- Дотоод хяналтын хороо

Хороо нь Компанийн ажилтан, захирлууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн Компанийн үнэт цаасны арилжааг Компанийн Дотоод хяналтын бодлогын дагуу хянадаг.

- Компанийн засаглал ба мэдээлэл түгээх бодлогын хороо

Хороо нь хууль эрхзүйн шаардлагын дагуу мэдээллийг нээлттэй, ил тод байлгах, дотоод мэдээ ашиглан арилжаанд оролцохоос сэргийлэх бодлогод хяналт тавьж ажилладаг. Хороо нь мэдээллийн нээлттэй байдлын зохих систем, үйл ажиллагаа болон хяналтыг хангах үүрэгтэйгээс гадна мэдээллийг олон нийтэд мэдээллэхээс өмнөх бүхий л хэвлэлийн мэдээ, баримт бичгийг нягталдаг.

Мөн тус хороо нь ТУЗ-ийн үйл ажиллагааны, үр дүнг үнэлэхээс гадна бүтэц бүрэлдэхүүн болон хороодыг, ерөнхий гүйцэтгэлийг хянах үүрэгтэй. Гишүүн тус бүр аливаа асуудлыг Компанийн засаглал ба ил тод бодлогын хороо эсвэл ТУЗ-д өргөн барих эрхтэй.

- Техникийн хороо

Уг хороо нь аливаа хөрөнгө оруулалт, хамтын хөрөнгө оруулалт, нөөц, боломжуудыг ТУЗ-д танилцуулахаас өмнө тодорхойлж, хянан шалгахад удирдлагад туслан ажилладаг.

2.4 Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын тухай мэдээлэл

Компанийн гүйцэтгэх удирдлага нь 2 захирал болон 8 удирдах албан тушаалтнаас бүрддэг. Удирдлага ба техникийн баг нь Компанийн үйл ажиллагаа эрхэлж буй бүс нутгийн ашигт малтмалын хайгуул болон хөгжүүлэлтийн асуудлаар олон жил ажиллаж байгаа туршлагатай хамт олон. Одоогийн байдлаар Компанийн Канад дахь албан байранд 7 үндсэн ажилтан, Улаанбаатар хот дахь албан байранд (Компанийн охин компаниуд багтсан) 19 ажилтантай.

Улаанбаатар хотод байрлах албан байранд 19 ажилтнаас геологи хайгуулын мэргэжилтнүүд нь 4-12 сарын хооронд Компанийн Баян Хөндийн хээрийн ангид байрлаж ажилладаг.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх захирал:

Нэр: Петер С.Акерли

Албан тушаал: Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал

Петер С.Акерли нь ашигт малтмалын хайгуул, компанид санхүүжилт босгох томоохон төслүүдийг хэрэгжүүлэх болон олон улсын зах зээлд хувьцаа гаргасан нээлттэй хувьцаат компаниудад удирдах албан тушаал хашиж байсан 25 жилийн туршлагатай. Тэрээр үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч, захирлуудын нэг бөгөөд 2013 оны 3 сараас эхлэн тус компанийн Ерөнхийлөгч, гүйцэтгэх багийн тэргүүнээр ажиллаж байна. Петер С.Акерли нь геологич мэргэжилтэй бөгөөд Монгол Улсын молибдени, зэсийн томоохон нөөцийг тогтоох, Алтан Нар төслийн алтны нөөцийг тодорхойлох, илрүүлэх мөн Баян Хөндийн алтны төслийн хайгуулын ажил зэрэгт техникийн багийг ахлан ажиллаж байсан. 2004 онд компани хувьцаат компани болгосон цагаас хойш, хорь гаруй компанийн нэгдэх, нийлэх, хувьцаат компани болон өөрчлөн зохион байгуулах, түүнчлэн санхүүжилт, удирдлагын ажлыг гүйцэтгэж байсан арвин туршлагатай. Тэрээр Халифакс дахь Сейнт Меригийн их сургуулийг геологийн чиглэлээр шинжлэх ухааны баклавын (1988) зэрэгтэйгээр төгссөн ба “Компанийн захирлуудын аудитын хорооны үр ашиг институт”-ыг 2012 оны 12 сард дүүргэсэн.

Компанийн удирдлагын багийн мэдээлэл:

	Нэр	Албан тушаал	Ажлын туршлага
1	Петер С.Акерли	Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Дарга	Ашигт малтмалын хайгуул, компанийн санхүүжилт, төслийн хөгжил ба удирдлагын чиглэлээр 25 жил ажиллаж байгаа туршлагатай
2	Кеннет В. МакДоналд	Дэд ерөнхийлөгч ба Санхүү хариуцсан захирал	Ашигт малтмалын хайгуул, нягтлан бодох болон санхүүгийн салбарт 40 гаруй жил ажилласан туршлагатай
3	Майкл МакДоналд	Хайгуул хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуул, ашигт малтмалын нөөцийн бодлого зохицуулалт, хөгжлийн талаар 40 гаруй жилийн туршлагатай, Монгол улсад 25 жил ажиллаж байгаа туршлагатай
4	Майкл Гиллис	Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуулын салбарт 25 жил ажиллаж байгаа туршлагатай
5	Гэндэнжамцийн Бат-Эрдэнэ	Ахлах Геологич	Монгол улсын хайгуулын салбарт 25 жил ажиллаж байгаа туршлагатай
6	Багабандийн Баярмаа	Захиргаа хариуцсан дарга	Монгол улсын хайгуулын салбарын захиргааны чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай
7	Анхбаярын Билгүүн	Бизнес хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгч	Уул уурхайн санхүүжилт ба хөрөнгийн зах зээлийн чиглэлээр 15 жилийн туршлагатай

8	Жон М.Л. Лионс	Стратеги, захиргаа хариуцсан дэд ерөнхийлөгч	Засгийн газраас зөвшөөрөл авах, түүнтэй холбоотой үйл ажиллагааг хариуцан ажилладаг. Мөн эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн буй орчин болон олон нийтийн асуудлыг хариуцдаг
9	Даррин Бордерик	Санхүүгийн газрын дарга	Төрийн болон хувийн компаниудад санхүүгийн ахлах албан тушаалд ажиллаж байсан туршлагатай
10	Дасон Бриско	Компанийн хөгжил хариуцсан дэд ерөнхийлөгч	Ашигт малтмалын хайгуулын чиглэлээр 10 жилийн турш ажиллаж буй туршлагатай

Гурав. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтийн талаар²

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт \$4,293,436 канад долларын хөрөнгөтэй үүнээс мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь \$1,071,209 канад доллар байсан бол нийт \$182,644 канад долларын богино хугацаат өр төлбөртэй. Орлого, ашгийн хувьд компани нь хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй тул алдагдалтай ажиллаж байгаа. 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар үнэт цаас гаргагч нь нийт \$2,794,184 канад долларын алдагдал хүлээсэн байна.

Мөн компани нь Монгол болон Канад улсад үйл ажиллагаа явуулдаг тул гадаад валютын ханшийн эрсдэлд орох магадлал өндөр байна. Компанийн зүгээс уг эрсдлийг бууруулах, хязгаарлах зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөө Канад улсын банкинд байршуулдаг. Валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалан хязгаар тогтоох санхүүгийн хэлцлүүдийг ашигладаггүй, зөвхөн хайгуулын хөтөлбөрийн хуваарьт тулгуурлан Компанийн төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан

(Канад доллар)	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө:			
Мөнгө	1,071,209	675,790	136,824
Авлага	36,854	55,664	20,674
Урьдчилж төлсөн зардал	39,743	17,177	15,980
	1,147,806	748,631	173,478
Эргэлтийн бус хөрөнгө:			
Хайгуул, үнэлгээний хөрөнгө	3,066,211	1,737,592	10,676,010
Үндсэн хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмж	79,418	35,825	62,160
	3,145,629	1,773,417	10,738,170
НИЙТ ХӨРӨНГӨ	4,293,435	2,522,048	10,911,648

² Үнэт цаасны танилцуулгын хавсралт 12

ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ


Богино хугацаат өр төлбөр:			
Худалдааны болон бусад өглөг	182,644	188,083	309,146
Тиан По Ресурст төлөх хөрвөх өрийн бичиг	-	255,207	2,657
НИЙТ ӨР ТӨЛБӨР	182,644	440,290	311,803
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Хувьцаа эзэмшигчдийн өмч :			
Хувьцаат капитал	86,783,669	81,967,477	79,290,034
Хувь нийлүүлсэн нэмэгдэл	11,952,465	11,945,440	11,487,249
Хуримтлагдсан бусад			
Дэлгэрэнгүй орлого (гарз)	(636,283)	(341,838)	(1,295,742)
Алдагдал	(93,989,060)	(91,489,321)	(78,881,696)
	4,110,791	2,081,758	10,599,845
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	4,293,435	2,522,048	10,911,648

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлан

(Канад доллар)	2016 оны 12 дугаар сарын 31	2015 оны 12 дугаар сарын 31	2014 оны 12 дугаар сарын 31
Хайгуулын зардал	2,171,792	1,502,565	1,900,651
Байгууллага, захиргаа	1,446,888	745,448	729,074
Бусад орлого	-	(1,443)	(1,039)
Валют арилжааны олз	(2,894)	(5,376)	(9,615)
Үйл ажиллагаа явуулснаас хүлээсэн алдагдал	3,615,786	2,241,194	2,619,071
Санхүүгийн орлого	11,955	4,926	2,935
Санхүүгийн зардал	-	(74)	(418)
Санхүүгийн цэвэр орлого	11,955	4,852	2,518
Дор дурдсанаас өмнөх алдагдал	3,603,831	2,236,342	2,616,553
Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын борлуулалтын орлогоос хувь авах эрхээ худалдсаны олз /Gain on the sale of Net Smelter Royalty Interest/	623,028	-	-
Түргэн борлогдох үнэт цаас борлуулсны олз	481,064	-	-
Хайгуул болон үнэлгээний ажилд зарцуулсан хөрөнгийн үнэ цэнийн бууралт	-	(10,371,283)	-
Цэвэр алдагдал	2,499,739	12,607,625	2,616,553
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал):			
Гадаад дахь охин компаниудын гадаад валютын хөрвүүлгээс үүдсэн ханшийн зөрүү	(294,445)	953,904	283,947
Бусад дэлгэрэнгүй орлого (алдагдал):	(294,445)	953,904	283,947
Нийт дэлгэрэнгүй алдагдал	2,794,184	11,653,721	2,900,500
Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон хорогдуулсан алдагдал	0.02	0.14	0.04
Гаргасан хувьцааны тайлант үеийн үндсэн болон хорогдуулсан нийт тооны жигнэсэн дундаж	117,127,676	92,590,453	74,255,417

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн шинжилгээний үзүүлэлтүүд


График 1. Эргэлтийн харьцаа (2012-2016)



Эргэлтийн харьцаа нь богино хугацаат өр төлбөр төлөх компанийн чадварыг илтгэдэг. Тус Компани нь TSX биржид бүртгэлтэй тул хамгийн өндөр харьцаа нь 89.7, хамгийн бага нь 0.21 байна.

2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн хамгийн сүүлийн үеийн эргэлтийн харьцаа 6.27 байв. Салбарын эргэлтийн дундаж нь 2.38 байгаа нь компанийн эргэлтийн харьцаа эрдэс баялаг, металлын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудынхаас өндөр байгааг илтгэж байна.

График 2. ROA ба ROE (2012-2016)



Хөрөнгийн өгөөж (ROA) нь нийт хөрөнгийн өгөөжийн хувь хэмжээг илэрхийлдэг ба компанийн өөрийн хөрөнгө болон өр төлбөрийн нийлбэр буюу нийт хөрөнгөөс олох компанийн үр ашгийг илэрхийлдэг. 2004 оноос хойш Компанийн хамгийн өндөр ROA - 3.6%, хамгийн бага -187.7% байна. Салбарын дундаж нь -8.8 байгаагаас харахад Компанийн ROA багад тооцогдохгүй.


График 3. EV/EBIT (2012-2016)



2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант улиралд Компанийн Үнэ Цэнэ (EV) 63.87 сая канад доллар байв. EBIT-ийг 2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон арван хоёр сараар тооцоолов.

Одоогоор Компанийн EV/EBIT харьцаа салбарын дундаж болох 14.7-оос бага байна.

График 4. P/B харьцаа (2012-2016)



P/B харьцаа нь хувьцааны зах зээлийн үнийг компанийн бодит хөрөнгөтэй харьцуулсан харьцаа юм. 2016 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусгавар болсон тайлант улиралд Компанийн хувьцааны хаалтын үнэ 0.70 доллар байв.

Салбарын одоогийн дундаж нь 2.01 байна. Компанийн орлого хасах утгатай байгаа тул PE харьцаа хэрэглэгдэхгүй. Энэ нь компанийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой юм.

Дөрөв. Санал болгож буй үнэт цаасны талаар

4.1 Санал болгож буй үнэт цаасны мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй бирж:	Канад, Торонтогийн хөрөнгийн бирж
Гаргасан хувьцааны тоо:	146,400,586
Хувьцааны төрөл:	Энгийн хувьцаа
Монголын Хөрөнгийн биржийн бүртгэл:	Давхар бүртгэл (Cross listing)
МХБ-ийн бүртгэлийн ангилал:	III ангилал
МХБ-д бүртгүүлэх хувьцааны тоо:	4,000,000 хүртэлх Энгийн Хувьцаа
Анхдагч зах зээлд гаргах арга:	Тогтоосон үнийн аргаар
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт:	Хайгуулын өрөмдлөг, нөөцийн тооцоолол ба техникийн судалгаа

4.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэрийн талаар

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлэн олон нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн шийдвэрийг 2018 оны 02 сарын 28 өдөр гаргасан байна. Уг шийдвэрийн дагуу 4,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцаа буюу компанийн нийт хувьцааны 2.7 хүртэл %-ийг Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэхээр хүсэлтээ хүргүүлж байгаа.

4.3 Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах талаар

Үнэт цаас гаргагч нь нийт энгийн хувьцааны 2.7 хүртэл %-тай тэнцэх 4,000,000 ширхэг хүртэлх энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан ТОГТООСОН ҮНИЙН АРГААР санал болгон арилжаалахаар “Үнэт цаасны танилцуулга”-д тусгасан.

Үнэт цаасыг санал болгох ажиллагаанд firm commitment нөхцлөөр андеррайтертай хамтран ажиллаж байгаа, хувьцааны эрэлт давсан тохиолдолд тодорхой үнийн дүн бүхий хувьцааг бүрэн биелүүлэх, түүнээс давсан дүнд хувь тэнцүүлэн эзэмшүүлэх зэрэг асуудлыг зохицуулан “Үнэт цаасны танилцуулга”-д тусгасан нь нэг талаас МХБ-ийн бүртгэл амжилтгүй болох, хувьцаа бүрэн арилжигдахгүй байх эрсдэлийг хаасан, нөгөө талаас эрэлт өндөр гарсан нөхцөлд хөрөнгө оруулагч бүр зохих хэмжээгээр хувьцаа худалдан авах, олон жижиг хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцох бололцоог нээж өгсөн байна.

Үнэт цаасны танилцуулгад анхдагч зах зээлд хувьцааг байршуулах асуудлыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

Хувьцаа арилжаалах зөвшөөрөл авах

- Компани МХБ болон СЗХ-д үнэт цаасаа бүртгүүлэх хүсэлт гаргана

Хувьцааг арилжих нөхцөл

- Хувьцааг МХБ-ийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын гуравдугаар зүйлд заасны дагуу тогтоосон үнийн аргаар санал болгон арилжина.
- Хувьцааг санал болгох явцад худалдан авах эрэлт давсан нөхцөлд захиалга бүрийн 2,500,000 хүртэлх төгрөгийн худалдан авах захиалгыг бүрэн биелүүлэн үлдэх хувьцааг 2,500,000 төгрөгөөс илүү гарсан захиалгын дүнтэй харьцуулан хувь тэнцүүлэн арилжих аргыг баримтлана. Хувьцааны захиалгын тоо (захиалгын гэрээ) хэтэрснээс үүдэн тогтоосон босго дүнгээр захиалгыг биелүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдол бүрд босго үнийн дүнг 50 хүртэлх хувиар бууруулан шинэчлэн тогтооно. Ингэхдээ үнэт цаас гаргагч болон андеррайтер нь МХБ-тэй зөвшилцөнө.
- Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн хувьцааны бүртгэлийн III ангилалд бүртгэгдэж байгаа бөгөөд МХБ-ийн “Бүртгэлийн журам”-ын 13.1.2, 13.1.3-т “...III ангиллын үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгох, бусад этгээд худалдан авах тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргасан тухай үйлчлүүлж буй брокерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад бичгээр мэдэгдэн” худалдан авч болохоор зохицуулсан.

Иймд үнэт цаасны компаниуд нь мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш харилцагчаас хувьцаа худалдан авах захиалга авахдаа МХБ-ийн “бүртгэлийн журам”-ын 13.1.3-т заасан “ТУХАЙН ҮНЭТ ЦААСЫГ МЭРГЭЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД САНАЛ БОЛГОСОН БОЛОХЫГ ОЙЛГОЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАСАН ТУХАЙ” мэдэгдлийг бичгээр авсан байна.

- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан уг нөхцөл байдал, журмын зохицуулалтыг танилцуулаагүй, бичгээр мэдэгдэл аваагүйгээс харилцагчдад учирсан хохирлыг үнэт цаас гаргагч болон андеррайтер хариуцахгүй.

Хувьцааг олон нийтэд танилцуулах

- Байгууллагын болон маркетингийн стратеги боловсруулж, Үнэт цаасны танилцуулга болон танилцуулгын хураангуйг боломжит хөрөнгө оруулагчдад танилцуулах.
- Roadshow: Үнэт цаасны танилцуулга (roadshow) зохион байгуулах төлөвлөгөө гаргаж, боломжит хөрөнгө оруулагчидтай уулзаж, танилцуулах.

- Санал болгож буй хувьцаатай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх.

Захиалга хүлээн авах, биелүүлэх

- СЗХ-ны зөвшөөрлийн дагуу МХБ-тэй хамтран захиалга хүлээн авч эхлэх болон хаах хугацааг тогтоох,
- ҮЦК-иудад арилжааны талаарх зааварчилгаа, мэдээлэл өгөх,
- ҮЦК-иуд худалдан авах захиалгыг биржийн программд шивэх,
- Захиалга хаагдсанаар хувьцаа худалдан авах захиалгын дүнг нэгтгэн МХБ-тэй хамтран нийлүүлэх аргачлалыг тогтох. Хувьцаа худалдан авах захиалга нийлүүлэх дүнгээс илүү гараагүй нөхцөлд захиалгыг шууд биелүүлэн үлдэх хувцааг андеррайтерууд худалдан авах, илүү гарсан нөхцөлд хувь тэнцүүлэх аргыг хэрэглэнэ.
- Сонгосон аргачлалын дагуу хувьцаа худалдан авах захиалгыг СЗХ-ноос зөвшөөрөл авснаар биелүүлнэ.

Хувьцаа худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид:

- МХБ-д бүртгэлтэй ҮЦК-иудаас сонгож, үнэт цаасны данс нээлгэнэ,
- Үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгө байршуулна.

Хүлээн авагч банк: Арилжаа төлбөр тооцоо банк

Хүлээн авах данс: ХХХХ (ҮЦК-ийн код) ХХХХХХХХХХ (Харилцагчийн үнэт цаасны дансны дугаар)

Хүлээн авагч: (данс эзэмшигчийн нэр)

Утга: Эрдэнэ ресурс хувьцаа худалдан авах мөнгө

- Сонгон үйлчлүүлж буй үнэт цаасны компанидаа хувьцаа худалдан авах захиалгаа өгөх, гэрээ байгуулах.

4.4 Үнэт цаасаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь “Хөндий” хэмээн нэрлэгдэх болсон алтны бүлэг ордуудыг агуулсан байх магадлалтай геологийн бүсийг нээж хоёр ч хайгуулын төсөл нь эцсийн шатанд орсон. Энэхүү хайгуул, үнэлгээний үр дүнгээс харахад хэмжээ болон агуулгын хувьд цаашид олборлолт хийх боломж өндөр, хүдрийн биетүүдийн байрлалаас хамааран томоохон хэмжээний алтны бүлэг ордууд байх боломжтой гэж үздэг. Үүнд Баян Хөндий, Алтан Нар болон бусад анхан шатны нээлтүүд болон зэргэлдээ хайгуулын талбайнууд багтаж байна. Эдгээр талбайн хэмжээ болон агуулгыг тодорхойлох нь үнэт цаас гаргагчийн ойрын хугацааны зорилт юм.

Дараагийн үе шатанд төслүүдийн боломжит эрдсийн нөөцийг тогтоох ажил хийгдэнэ. Эрдсийн нөөцийг тогтоосноор хүдрийн биетийн төрөл болон олборлолтын арга барилд тулгуурлан урьдчилсан эдийн засгийн тооцооллыг гаргах боломжтой. Урьдчилсан эдийн засгийн тооцоололд тулгуурлан нарийвчилсан үнэлгээнүүд хийгдэх бөгөөд энэ нь цаашид

орд болон боловсруулах үйлдвэрийн байгууламж, олборлолтын үйл ажиллагааг эрхлэх ажлын эхлэл болно. Компани 2018 болон 2019 онуудад нөөц тогтоолт болон эдийн засгийн тооцоололтой хамт ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх ажлуудыг хийнэ.

Үнэт цаас гаргагчийн 2018 оны техникийн хөтөлбөрийн зарцуулалт

	2018
Удирдлагын зардал	
Хөрөнгийн зарцуулалт	6 000
Удирдлагын үйлчилгээ	724 433
Хууль болон аудит	152 900
Томилолтын зардал	140 000
Хурал, чуулга уулзалтууд	259 272
Зохицуулагч байгууллагуудад	250 000
Оффис болон бусад зардлууд	124 645
Морien удирдлагын авлага	(252 799)
Монгол дахь удирдлагын зардлууд	446 834
Нийт	1 851 285
Хайгуулын зардал	
Өрөмдлөг	1 529 200
Дээжний шинжилгээ	417 242
Нийт цалин	1 464 182
Туслан гүйцэтгэгч	130 982
Техникийн гэрээний үйлчилгээ	1 646 000
Геотехник	30 510
Геофизик	132 624
Хээрийн ангид	395 078
Хээрийн харилцаа холбоо	5 000
Хээрийн ложистик дэмжлэг	151 351
Томилолт	129 775
Тусгай зөвшөөрлийн төлбөр	105 290
Бусад	22 225
Хайгуулын зардлын дүн	6 159 459
Үндсэн хөрөнгө	6 000
Нийт зардал	8 016 744

2018 оны хайгуулын зардал төслөөр

Төслүүд	2018
Хөвөн Хар / Зуун Мод	86 360
Алтан Нар	1 389 717
Баян Хөндий	3 673 677
Алтан Сум	585 435
Лидер - Улаан	408 010
Теск	16 261
Нийт	6 159 459

4.5 Үнэт цаас худалдан авахад анхаарах зүйлс

Үнэт цаас гаргагч нь хайгуулын үйл ажиллагаа эрхэлдэг компани тул 2018-2020 оны хооронд тогтвортой орлогын эх үүсвэр бий болох магадлал багатай тул хөрөнгө босгож, цаашдын санхүүжилтийг бий болгохоор төлөвлөж байгаа. Түүнчлэн энэхүү үнэт цаасны танилцуулгын хүрээнд Санхүүгийн тайлангийн таамаглал, хөрөнгө оруулалтын өгөөж болон мөнгөн гүйлгээний төсөв хийгдээгүй, МХБ-ээр татан төвлөрүүлэх хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн

2018 онд төлөвлөж буй зардалд хүрэлцэхгүй тул цаашид олон улсын хөрөнгийн захаас санхүүжилт босгох магадлал өндөр.

Мөн компани нь Монголын Хөрөнгийн Биржийн III ангилалд бүртгэгдэж олон нийтээс хөрөнгө оруулалт татаж байгаа ба энэ ангилал нь мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд санал болгох, хэрэв бусад этгээд худалдан авах тохиолдолд тухайн үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад санал болгосон болохыг ойлгож шийдвэрээ гаргах журмын зохицуулалттай.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийн талаарх Монгол Улсын хууль тогтоомж болон үнэт цаас гаргагчийн бүртгэлтэй улсын хууль тогтоомжийн хооронд зөрүүтэй байдал, зохицуулалт үүсэх магадлалтай. Энэ тохиолдолд Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журамд³ үнэт цаас гаргагчийн харъяалагдах улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхөөр заасан.

Иймд хөрөнгө оруулагч нь эдгээр нөхцөл байдлыг анхаарч, үнэт цаасны танилцуулгад дурдсан мэдээлэл, компани болон хөрөнгө оруулагчдад учирч болзошгүй эрсдэлийн талаар сайтар судалж үнэт цаас гаргагчийн санал болгож байгаа хувьцааг худалдан авах шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагчдын үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлд цаашид олборлолтын үе шат хүртэл хайгуулын үр дүнг судалж, шаардлагатай лиценз болон зөвшөөрлийг авах хүсэлтээ холбогдох байгууллагуудад 2018, 2019 гаргах, тогтвортой үйл ажиллагааг эрхлэх зэрэгт зорьж ажиллахаар төлөвлөж буйг мөн дурдах нь зүйтэй.

Нэгтгэн дүгнэвэл, Эрдэнэ Ресурс Девелопмент Корп нь Канад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, албан ёсны бүртгэлтэй хуулийн этгээд бөгөөд 2004 онд өөрийн улсын холбогдох үнэт цаасны хууль тогтоомжийн дагуу ТХБ-ийн Вентчур ангилалд бүртгүүлэн олон нийтийн компани болсон (TSXV: ERD). 2005 оны 12-р сард ТХБ-ийн үндсэн ангилалд шилжин (TSX: ERD) нэрээр бүртгэгдсэн хууль ёсны компани байна⁴.

Тус компани Монгол улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан өөрийн охин компани болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресурс ХХК болон Лидер эксплорейшн ХХК зэрэг компаниудаар дамжуулан одоогийн байдлаар 17,861.20 га бүхий 7 төслийн талбайд ашигт малтмалын хайгуулын 4, ашиглалтын 1 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг⁵. Эдгээрээс Алтан нар /ТЗ: XV-016956. Цэнхэр Номин/, Баян Хөндий /ТЗ: XV-015569. Хөндий/ төслийн талбайнуудад явуулж буй хайгуулын ажил нь алт, алт-зэс-полиметалын хувьд нөөц тооцоолон тайлагнах

³ “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй Хуулийн этгээд монгол улсад үнэт цаас гаргах, Монгол улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах Үнэт цаасыг бүртгэх журам”-ын 1.5 дугаар заалт

⁴ Хавсралт 10. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшний Монголын Хөрөнгийн Биржид гаргах энгийн хувьцааны давхар бүртгэлд зориулсан хууль зүйн дүгнэлт.

⁵ Хавсралт 5-7. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хуулбарууд

түвшинд хүрч байгаа гэж үзэж байгаа бол Зуун мод /молибден-зэс/, Хөвийн хар /зэс-мөнгө/ төслүүдийн хувьд одоогийн нөхцөлд олборлолтын өртөг өндөр, эдийн засгийн үр ашиггүй гэж үзжээ⁶.

Баян Хөндийн талбайн дээжид хийсэн туршилтаар хүдэр дэх алтны 90 гаруй хувийг ялган авах боломж байгааг тогтоосон нь эдгээр талбай дээр цаашид ордын нөөц тооцоолох, улмаар ашиглалт явуулах бололцоо нээлттэй байгааг илтгэдэг. Энэ талбайн хүрээнд хамардаг өндөр алтны агуулгатай Хүрэн цавын гадаргуугаас нүдэнд үзэгдэх алттай кварцын судлууд цөөнгүй ажиглагддаг ба эдгээрт хийсэн анхдагч геохимийн сорьцлолтоор нэн өндөр агуулга тогтоогдсон нь дунджаар 5-10г/т байжээ.

Иймд энэ цаг хугацаанд үнэт цаас гаргагч нь хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж байгаа нь ойрын ирээдүйд ашиглалтын үр ашгаа өгөх уул уурхайн төсөлд Монгол иргэд, хөрөнгө оруулагчдыг оролцох, уул уурхайн төслөөс бодит өгөөж хүртэж эхлэх бололцоог бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Үнэт цаасыг санал болгох ажиллагаанд firm commitment нөхцлөөр андеррайтертай хамтран ажиллах гэрээтэй, хувьцааны эрэлт давсан тохиолдолд тодорхой үнийн дүн бүхий хувьцааг бүрэн биелүүлэх, түүнээс давсан дүнд хувь тэнцүүлэн эзэмшүүлэх зэрэг асуудлыг зохицуулан “Үнэт цаасны танилцуулга”-д тусгасан нь нэг талаас МХБ-ийн бүртгэл амжилтгүй болох, хувьцаа бүрэн арилжигдахгүй байх эрсдэлийг хаасан, нөгөө талаас эрэлт өндөр гарсан нөхцөлд хөрөнгө оруулагч бүр зохих хэмжээгээр хувьцаа худалдан авах, олон хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцох бололцоог нээж өгчээ.

Андеррайтерийн “БиДиСЕК ҮЦК” ХК

Монгол Улс, Улаанбаатар хот

2018 оны 03 сарын 12-ны өдөр

⁶ Хавсралт 18. Мэргэшсэн геологичийн хөндлөнгийн дүгнэлт, Хавсралт 27. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт